

БАТЛАВ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Г.ӨНӨРБАЯР

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2020 ОН ХҮРТЭЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгууллагын нэр: ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

д/д	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага			Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
				Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Бусад оролцогч байгууллага		
4.1.1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх								
	4.1.1.1 төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх;	-Эрх бүхий байгууллагуудын дүгнэлт, саналыг үндэслэн Яам болон харьяа байгууллагын албан тушаалын томилгоог хуулийн дагуу хийх;  - Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/;  -Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх.	Сул орон тоо гарах бүр	ХНХЯам	Харьяа байгууллагууд	Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар		Хүний нөөцийн томилгоо хуулийн дагуу хийгдсэн байна.

<p>4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх;</p>	<p>-Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалд томилогдох иргэнийг Төрийн албаны зөвлөлөөс баталсан холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтын дүнгээр 1-д эрэмбэлэгдсэн болон Төрийн албаны тухай хууль /10 дугаар зүйл/-д заасан болзол шаардлага хангасан иргэдийн томилох, албан тушаал дэвшүүлэх зарчмыг баримтлан ажиллаж, үр дүнг тооцох, тайлагнах; -Ажлын байрны тодорхойлолтод авлигаас ангид, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах шаардлагыг тусгах.</p>	<p>Сул орон тоо гарах бүр</p>	<p>ХНХЯам</p>	<p>Харьяа байгууллагууд</p>	<p>Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар</p>	<p>-</p>	<p>Хүний нөөцийн томилгоо хуулийн дагуу хийгдсэн байна.</p>
<p>4.1.1.4.төрийн жинхэнэ албан хаагчийг томилох, чөлөөлөх асуудлыг төрийн өндөр албан тушаалтан болон улс төрийн намын нөлөөллөөс ангид байлгах;</p>	<p>-Аливаа томилгоо, чөлөөлөхтэй холбоотой шийдвэр гаргахдаа Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг баримтлан ажиллаж, үйл ажиллагаандаа хэвшүүлэх.</p>	<p>Тухай бүр</p>	<p>ХНХЯам</p>	<p>Харьяа байгууллагууд</p>	<p>Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар</p>	<p>-</p>	<p>Хүний нөөцийн томилгоо хуулийн дагуу хийгдсэн байна.</p>
<p>4.1.1.5.авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх;</p>	<p>-Яамны хэмжээнд авлигын эрсдэлийн үнэлгээний суурь судалгаа хийж, бодлогод дэмжлэг үзүүлэх.</p>	<p>2017 онд</p>	<p>ХНХЯам</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Судалгаа хийгдсэн байна.</p>
<p>4.1.1.6.нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан</p>	<p>-Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгаж, батлах, мөрдүүлэх;</p>	<p>2017 он</p>	<p>ХНХЯа м</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Ёс зүйн дүрэм батлагдсан</p>

	<p>нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх;</p>	<p>-Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх;</p> <p>-Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах;</p> <p>-Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэсэн байх.</p>					-	байна
	<p>4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;</p>	<p>-Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих ёс зүйн хороо байгуулах, зөрчил хянан шийдвэрлэх журам боловсруулан мөрдөх;</p> <p>-Дотоодын хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах, шат шатны удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, гаргасан шийдвэрийг иргэдэд ил тод мэдээлэх, сурталчлах ажиллагааг салбарын хэмжээнд зохион байгуулах, үр дүнг тооцох.</p>	Тухай бүр	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Нийтийн албан хаагчид хуульд нийцүүлэн ажилласан байна.

	4.1.1.8.шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр хууль бус болох нь тогтоогдсон тохиолдолд шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учруулсан хохирлыг төлүүлэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;	- шүүхийн болон дээд шатны удирдлагын шийдвэрээр хууль бус шийдвэр гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэр хүчингүй болсон тохиолдолд гэм буруутай этгээдэд хариуцлага ногдуулах, үр дагаврыг арилгуулж, учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, хэрэгжүүлэх.	Тухай бүр	ХНХЯам			-	Шийдвэр үнэн зөв гарсан байна
<b>4.1.2.Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх</b>								
	4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх;	-Байгууллагын цахим хуудаст үйл ажиллагааны мэдээллийг байрлуулан тогтмол шинэчилж ажиллах; - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх.	2017 он	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Төрийн үйлчилгээ нээлттэй ил тод явагдана.
	4.1.2.2.зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх;	- Яамнаас олгож буй тусгай зөвшөөрлийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах; -Зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсанд байршуулах; -Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах.	Хагас, бүрэн жилээр	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Иргэдэд хуулийн дагуу хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлнэ.

<p>4.1.2.6. өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх;</p>	<p>- Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх;</p> <p>- Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр);</p> <p>- Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах;</p> <p>- Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, хариуг тогтмол мэдээлж хэвших.</p>	Улирал тутам	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд үнэн зөв барагдуулсан байна.
<p>4.1.3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</p>							
<p>4.1.3.1. улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх;</p>	<p>- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт байгууллагын шилэн дансны мэдээлэлд байршуулна.</p>	Улирал тутам	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Төсөв санхүүгийн зарцуулалт хуульд нийцсэн байна.

	<p>4.1.3.2.төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p>	<p>Улсын төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийн хагас, бүтэн жилээр шилэн дансны мэдээлэлд байршуулах; -Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах.</p>	Улирал тутам	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд		Төсөв санхүүгийн зарцуулалт хуульд нийцсэн байна.
	<p>4.1.3.3.Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох;</p>	<p>- Тусгай сангуудын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, аудитлагдсан тайланг shilendans.gov.mn вэб сайтад хуулийн хугацаанд оруулах.</p>	Улирал тутам	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд		Төсөв санхүүгийн зарцуулалт хуульд нийцсэн байна.
	<p>4.1.3.6.нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;</p>	<p>-Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах;  - Хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлсэн байх; /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр/.</p>	Улирал тутам	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд		Хяналт шалгалт хуульд нийцсэн байна.
	<p>4.1.3.10.төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, нийтийн алба, албан тушаалтны үйл ажиллагаа, түүний үр дүнг иргэд, олон нийтийн хяналтад оруулах;</p>	<p>- Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;  -Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан</p>	Улирал тутам	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд		Зөвлөмжийн хэрэгжүүлэн ажилласан байна.

		байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх.						
4.1.5. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах								
	4.1.5.13. хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх;	Яам болон харьяа байгууллагын хэмжээнд ХАСХОМ гаргадаг албан тушаалтны жагсаалтыг тодорхой болгох, хуулийн хугаацаанд ХОМ өгүүлж хэвших.	Тухай бүр	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Холбогдох албан хаагчид хуульд зааснаар ХАСХОМ өгсөн байх
	4.1.5.14. хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягыг боловсронгуй болгож, мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх;	-Нийтийн албан тушаалд томилогдох албан хаагчийн ХАСУМ-ийг албан тушаалд томилогдохоос цахимаар өгч хэвших.	Тухай бүр	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Холбогдох албан хаагчид хуульд зааснаар ХАСУМ өгсөн байх
	4.1.5.16. хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх;	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/.	Тухай бүр	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Нийтийн алба хуулийн дагуу явагдах.
4.1.7. Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих								
	4.1.7.1. төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа	-Боловсруулж буй хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон	Байнга	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллага	-	төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг

	<p>явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих;</p>	<p>нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх;</p> <p>- Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, яамнаас гаргаж байгаа нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулсан байх;</p> <p>-Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх.</p>						<p>шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулж, санал авсан байна.</p>
	<p>4.1.7.3.төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;</p>	<p>-Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/;</p> <p>-Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулах;</p> <p>-Байгууллагын төсөв боловсруулах, гүйцэтгэх тайлагнах үйл явцыг нууцад хамаарахаас бусдыг ил тод, нээлттэй мэдээлэх нөхцлийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, хэрэгжүүлсэн байх.</p>	Тухай бүр	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	,	Төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих



	4.1.7.4.орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах;	Яам, харьяа агентлагийн дэргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг байгуулах, ажиллах дүрэм, журмыг батлаж, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох.	2017 онд	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын зөвлөл байгуулсан байна.
4.1.10.Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх								
	4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;	- Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах; -ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх; -Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх.	2017 онд	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авагдсан байна.
	4.1.10.4.авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;	-Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх; -Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байх; -АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ.	2017 онд	ХНХЯам	Холбогдох байгууллага	Харьяа байгууллагууд	-	Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авагдсан байна

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ